

Голомт банкны тэтгэлэг

Ерөнхий мэдээлэл: Жил бүр 100 оюутанд олгодог. Санхүү эдийн засаг, банкны чиглэлээр сурч буй оюутнуудыг түлхүү авдаг.

Хугацаа: 9 сард зарлаад 11 сард дүн нь гардаг.

Шалгуур: 1. Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийн өдрийн ангид суралцагч, 3, 4-р курсийн оюутан байх. 2. 3.5 болон 92 онооноос дээш голч үнэлгээтэй, урлаг, спортын авьяас, нийгмийн идэвх сайтай байх гэсэн үндсэн шаардлагатай.

Тэтгэлгийн хэмжээ: 700 мянган төгрөг

Шалгаруулах үйл явц: 4 үе шаттай. Шат бүрт оюутнуудыг хасан хассаар эцэст нь 100 шилдэг оюутанд тэтгэлэг олгодог.

1-р шат

Өөрийн сайн мэдэх гадаад хэлээр тодорхой сэдвийн дагуу 500-аас дээш үгтэй эссе бичиж өгнө. Үүнийгээ CV, дүнгийн хуулбар, шагнал өргөмжлөлтэйгөө хавсаргаж өгнө.

2-р шат

IQ болон англи хэлний тест авдаг. Энэ хоёр шалгалтын даалгаврууд тийм ч хүнд биш, дундаж гэж хэлж болно. Ерөнхийдөө TOEFL-ийн шалгалт өгч байсан эсвэл бэлдэж байгаа хүний хувьд маш амархан. Харин анхаарах зүйл бол тестний цаг нь тун бага байдаг. Иймд хурд хэрэгтэй. 2-р шатны шалгаруулалтын өмнө сэтгэлгээгээ сэргээх IQ тестүүд бөглөөд ороход гэмгүй.

3-р шат

2012 онд энэ үе шат байгаагүй ба 2013 онд нэмэгдсэн байсан. Энэ үе шатаар оюутны мэдлэг биш харин хувийн чадварыг сорьсон даалгаврууд хийлгэдэг. Жишээ нь 2013 онд: 1 минутын дотор жижиг эх уншина. Ингээд тухайн эхийн гол санааг аватум цаасан дээр зурж дүрслээд 1 минутын дотор ярьж тайлбарлана. Надад сургамжит өгүүллэг номын нэг богино өгүүллэг ирж байсан. Тус шатанд нийт 3 шүүгч байдаг. Ингэхдээ таны хурд, сэтгэх, агуулгыг өөрийн болгох, ярианы чадварыг зэрэг шалгачихдаг. 2014 онд 3-р

шатны даалгавар сэтгэх чадвараас гадна багийн ажиллагааг сорьсон чиглэлтэй байсан. Тиймээс энэ шатны даалгавар жил бүр өөрчлөгддөг гэж ойлгож болно.

4-р шат

Сүүлийн шат бол ярилцлага. Нийт 4 шүүгч байна. 10, 10-аараа групп болж, ярилцлагандаа орно. 10 оюутнууд маань ээлж ээлжээрээ өөрийгөө танилцуулж, шүүгчдийн асуултанд хариулна. Өөрийгөө гадаад хэлээр танилцуулж ч болдог. Миний хувьд англиар танилцуулж байсан. Шүүгчид ихэвчлэн “Тэтгэлэгээ хэрхэн зарцуулах вэ?”, “Бид яагаад таныг сонгож тэтгэлэг өгөх ёстой вэ?” зэрэг асуултандаа янз бүрийн хэлбэрээр хариулт авахыг хүсдэг.

Намайг ярилцлаганд орж байхад нэг оюутан тэтгэлгийн мөнгөөрөө гэртээ цэцэрлэг ажиллуулж, орцныхоо айлын хүүхдүүдийг үнэгүй харж өгнө. Гэрээ тохижуулах мөнгө хэрэгтэй байна гэж ярьж байсан. Харамсалтай нь тэр тэнцээгүй. Төгсөх ангийн оюутан хичээл, шалгалттай энэ үед хүүхэд харна гэдэг магадгүй шүүгчдэд итгэл үнэмшил төрүүлээгүй байж мэднэ.

Эдгээр 4 үеийг давж чадсанаар тэтгэлэг авна даа. Өөрийн тань зурагтай Голомт банкны дансны картыг банкнаас бэлэглэж, тус картанд тань тэтгэлэгийг байршуулдаг. Тус тэтгэлэгт зөвхөн 3, 4-р курсийн оюутан оролцох эрхтэй. Мөн 3-р курстээ тэтгэлэг авсан байсан ч 4-р курстээ буюу дараа жил ахин авах боломжтой байдгаараа онцлог. Дэлгэрэнгүйг www.golomt.mn вебсайтаас аваарай.